БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

# ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

*/Ойн зурвас байгуулах ажил/*

2024 он Дархан-Уул аймаг

| № | Үзүүлэлт | Шаардлага |
|---|---|---|
| 1 | Үндэслэл | Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.2.3 Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, цөлжилтөөс сэргийлэн ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. 4.1.2.6 Нутгийн иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагад байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хариуцуулан гүйцэтгүүлж, нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг зүй зохистой ашиглана" гэж заасан. |
| 2 | Захиалагч байгууллага | Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар |
| 3 | Газрын байршил | Орхон сумын Бүрэн толгой-2 га /Зургийг хавсаргав/ |
| 4 | Бэлтгэл үе шат | Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг сургаж, дадлагажуулах;<br>Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд хэрэглэх техник, тоног төхөөрөмжийг бэлэн болгоХамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын технологийн карт, технологийн дараалал боловсруулах;<br>Хамгаалалтын ойн зурвас байгуулах талбай сонгож, хүлээж авах ажлыг Сум дундын ойн анги, сумын Засаг даргын тамгын газартай зөвшилцөн сонгох/;<br>Улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэх өгөх:<br>Ажил гүйцэтгэгч, захиалагч, гүйцэтгэх хугацаа, талбайн хэмжээ, тарьсан модны тоо, схем зэрэг мэдээлэл агуулсан самбар байрлуулах |
| 5 | Хамгаалалтын ойн зурвас байгуулах | Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын нормативт зардлын хүрээнд сонгосон талбайд хашаа барих;<br>Хашааны шон газрын гадаргаас дээш 1,6 метр өндөртэй, шон хоорондын зай 3,0 метр байх;<br>Хашааны шонгийн урт 2.0 м, 40 мм диаметртэй төмөр хийцтэй байх бөгөөд шонг 0.4 м гүнд суулгаж, бетон суурьтай байх;<br>Хашааны шон хооронд 3 эгнээгээр давхар эрчилсэн өргөстэй төмөр утсаар татаж бэхлэх;<br>Хашааны тор нь 6*6 см-ээс ихгүй хэмжээтэй нүхтэй, 3 мм- ийн сүлжмэл төмөр торыг хашааны төмөр шонтой бэхэлсэн байх;<br>Хашаан доогуур мэрэгч амьтан болон мал орохоос хамгаалах, нэмэлт тор хийх;<br>Усны эх үүсвэр, газрын налууг харгалзан явган хүн, автомашины орц, гарцыг гаргах, автомашинд зориулж 3-4 метр өргөн, явган хүнд зориулж 1-2 метр өргөн хаалгыг суурилуулсан байх;<br>"Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага" MNS 6141:2010 стандартыг мөрдөх бөгөөд 1 |

<table>
<tr><td></td><td></td><td>дүгээр зэргийн суулгацуудыг ойн зурвас байгуулах ажилд хэрэглэх;<br>“Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах арга. Ерөнхий шаардлага” MNS 6258-1:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэх;<br>Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 4-р сарын 30- наас 5-р сарын 10 хүртэл хийх бөгөөд, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилтыг 9-р сарын 25-наас 10-р сарын 15- ны дотор тус тус хийх;<br>Тарилтын схем нь эгнээ хооронд 3.5-4.0 метр, мод хооронд 2.5-3.0 метр буюу 1 га талбайд 800-аас доошгүй ширхэг суулгацаар тарилтыг хийх;<br>Тарьсан суулгацыг арчлах, гадны хүчин зүйлээс хамгаалах, тогтмол усалгааны ажил гүйцэтгэх;</td></tr>
<tr><td>6</td><td>Талбайг хүлээлгэн өгөх, ажлын явцын хяналт тавих</td><td>Тухайн гүйцэтгэгч байгууллага ажлын 5 өдрийн өмнө гүйцэтгэсэн ажлаа хүлээлгэж өгөх мэдэгдэх хуудас, хүсэлтээ өгнө.<br>Ойн зурвас байгуулсан талбайг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгнө.<br>Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайг Ойн тухай хуулийн 18.2.4 дэх заалтын дагуу тухайн суманд акт үйлдэн хүлээлгэн өгнө.<br>Актыг 3 хувь үйлдэх бөгөөд аймгийн ЗДТГ, аймгийн БОАЖГ-т эх хувиар нь ирүүлнэ.<br>Амьдралтын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29 өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.<br><table><tr><th>Хамгаалалтын ойн зурвасын талбай /га/</th><th>Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь</th><th>Нэгж жишиг талбайн хэмжээ /$м^2$/</th></tr><tr><td>1-5</td><td>5</td><td>200</td></tr></table>Хамгаалалтын ойн зурвас байгуулсан ажлыг гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна.<br>Сум дундын ойн анги ойжуулах ажилд технологийн хяналт тавьж, хариуцсан байгаль хамгаалагч явцад нь дүгнэлт гаргана.</td></tr>
<tr><td>7</td><td>Зөрчил, гологдол арилгах</td><td>50-74.9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 100 хувь нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө.<br>25-49.9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.<br>25.0 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | төлүүлнэ. |
| 8 | Тайлан боловсруулах | **Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ**. Үүнд:<br>а/ "Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан";<br>б/ Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил явуулсан талбайн 1:50000 масштабтай зураг;<br>в/ "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх" журмын дагуу аймгийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.<br>**Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан"-д:**<br>а. Хамгаалалтын ойн зурвас байгуулсан ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана.<br>Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойн зурвасын ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана.<br>б. Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил явуулсан талбайн зурагт талбайн хилийн солбицол, дугаар, талбайн хэмжээ, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн заавpт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.<br>Тайланг аймгийн Засаг даргын ажил хүлээн авах ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайлангийн боловсруулалт шаардлага хангахгүй бол түүнийг сайжруулах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.<br>Тайланг сайжруулсан талаар төслийн менежер мэдэгдэл гарган дахин ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно. |
| 9 | Тайлан ирүүлэх | Гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь ажлын мэдээ тайланг гэрээний дагуу урьдчилсан мэдээг 06-р сарын 10-нд, эцсийн мэдээг 10-р дугаар сарын 10-ны дотор БОАЖГ-т ойн зурвас байгуулсан талбайг фото зургаар баримтжуулан хүлээлгэн өгнө. |
| 10 | Мэргэжлийн шаардлага, мэргэшсэн инженер техникийн ажилчдын хангамжид тавигдах шаардлага | **Мэргэжлийн шаардлага**<br>Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, нөхөрлөл, ТББайгууллага нь ойн зурвас хийхэд стандартын шаардлага хангасан тарьц суулгацын нөөцтэй байх, тарьц, суулгацыг нийлүүлэх гэрээ хийгдсэн байх<br>Ойжуулалт, ойг нөхөн сэргээх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага байх<br>Ойн зурвас ажилд шаардлагатай ажлын гар багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн мэдээлэл, түүний зургийг бүрэн харуулсан байх.<br>Өмнөх жилүүдэд хийсэн ойжуулалт болон адил төстэй<br>ажлын үр дүн /акт, гэрээний хувийг хавсаргах/ |

| | | |
|---|---|---|
| | | Ойжуулалтын ажлыг дараа онуудад арчлан тордох хэлбэр<br>Ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:<br>Ерөнхий инженер нь хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх,<br>Инженер техникийн ажилтан нь хамгаалалтын ойн зурвас байгуулж байсан бөгөөд 1 жилийн ажлын туршлагатай байх. |
| 11 | Ойжуулсан талбайг арчилж, тордох | Ойн зурвас байгуулсан талбайг 3 жилийн хугацаанд буюу ойн санд хүлээлгэж өгөх хүртэл арчилж, тордох ажлыг "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтран баталсан 2021.07.09-ны өдрийн А/172, 116 тоот тушаалыг үндэслэн дараа жилийн арчилгааны зардал олгох тул арчилж тордох ажлыг төлөвлөгөөнд тусгасан байх |
| 12 | Урьдчилгаа | Санхүүжилтийн урьдчилгаа 50 хувь, гүйцэтгэлээр 50 хувь |
| 13 | Нийт төсөвт өртөг | 22,500,000 /Хорин хоёр сая таван зуун мянга/ |

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ :

| № | Ажлын нэр, тодорхойлолт | Хэмжээ /га/ | Нийлүүлэх хуваарь |
|---|---|---|---|
| 1 | Бэлтгэл ажил | 2 | 2024-04-15-ны дотор |
| 2 | Хамгаалалтын ойн зурвас байгуулах | 2 | 2024-04-30-ноос 05-15 хүртэл |
| 3 | Талбайг хүлээлгэн өгөх | 2 | 2024-10-01-ний дотор |
| 4 | Зөрчил, гологдол арилгах | 2 | 2024-10-15-ны дотор |
| 5 | Тайлан боловсруулах | 2 | 2024-10-25-ны дотор |
| 6 | Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн | 1 удаа | 2024-11-01-ний дотор |

Зөвшөөрсөн: ХБТХОХ-ийн дарга П.Батсүх

Хянасан: Аймгийн Ерөнхий эдийн засагч Б.Батсүх

Боловсруулсан:
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн У.Мөнхзул

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН БҮРЭНТОЛГОЙД
# 2024 ОНД ХИЙХ ОЙН ЗУРВАС ГАЗРЫН ЗУРАГЛАЛ




Орчны зураг

Координатын систем:
WGS84/UTM 48N
EPSG5 32648



| № | X | Y |
|---|---|---|
| 1. | 563725.802 | 5498935.802 |
| 2. | 563774.918 | 5498920.142 |
| 3. | 563715.964 | 5498729.029 |
| 4. | 563668.333 | 5498744.236 |
| 5. | 563651.427 | 5498700.175 |
| 6. | 563698.857 | 5498683.740 |
| 7. | 563632.967 | 5498494.905 |
| 8. | 563585.723 | 5498511.276 |

**Таних тэмдэг**

- Ойн зурвас хийх газар
- Нэгж талбар

Талбайн хэмжээ: 20000 м.кв

Зураг үйлдсэн: ...../А.Үүрцайх/
( Сумын Газрын даамал )

1 centimeter = 70 meters

Хэвлэсэн огноо: 2023-12-15